



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/866

Ховд

Аймгийн Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Аргачлал батлах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг Гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.
4. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад жил бүр Хяналт-шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Ариунбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ